

## ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

### НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

Аймгийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж, нийт 3 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг ханган ажилласан.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлыг 2 удаа зохион байгуулж, 5 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссаны дагуу ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд “Нэг өрх –Нэг ажлын байр” арга хэмжээг хэрэгжүүлж эхэллээ. Тус арга хэмжээний хүрээнд өрхийн амьжиргааг тогтоох судалгаа хийж, өрхийн хөгжлийг дэмжих, орлогыг нэмэгдүүлэх, ажилгүй иргэдийг ажлын байраар хангах, халамжийг бууруулах чиглэлээр төлөвлөгөө гарган батлуулаад байна.

Манай аймгаас “Улсын аварга малчин” 1, “Аймгийн аварга малчин” 6, “Алтан төлийн эзэн” 4 шалгарсан бөгөөд Сар шинийн баярын өдрүүдээр шагналыг гардууллаа.

2022 оны 02 дугаар сарын 23-ны өдөр аймгийн Засаг даргаас сумдын Засаг дарга, харьяа газар, хэлтэс, агентлагийн дарга нартай 2022 онд хамтран ажиллах гэрээ байгуулж, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хянаж баталлаа.

Төр, хувийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан, албан хаагчдын санал, хүсэлтийг сонсож, үйл ажиллагаагаа сайжруулах зорилгоор 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдөр “Өглөөний уулзалт” арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээний хүрээнд аймгийн Засаг дарга, салбарын удирдах ажилтнууд эрүүл мэндийн салбарт ажиллаж буй залуу эмч, мэргэжилтнүүдийн төлөөлөлтэй уулзан, аймаг, орон нутгаас эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээний талаар танилцуулж, иргэдэд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах, салбарын хөгжлийн асуудлаар санал солилцлоо.

### ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

2022 оны 02 дугаар сарын нийт татварын орлогын төлөвлөгөө 1444493 мян.төгрөг төвлөрүүлэхээс хүлээгдэж буй гүйцэтгэлээр 1357287 мян.төгрөг төвлөрүүлж, 93.9 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс улсын төсвийн орлогод 208704 мян.төгрөг төвлөрүүлэхээс хүлээгдэж буй гүйцэтгэлээр 347685 мян.төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 66 хувиар давуулан биелүүлж, сумын төсвийн орлогод 1118859 мян.төгрөг төвлөрүүлэхээс 461810 мян.төгрөг төвлөрүүлж, 41.3 хувийн биелэлтэй байна. Мөн аймгийн төсвийн орлогод 116930 мян.төгрөг төвлөрүүлэхээс 547792 мян.төгрөг төвлөрүүлсэн бөгөөд төлөвлөсөн хэмжээнээс 4.7 дахин их орлого төвлөрүүллээ.

Татвар төлөгч аж ахуйн нэгжийн тоо 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 656 байна.

**Санхүүгийн хяналт, аудитын чиглэлээр:** Аймгийн хэмжээнд нийт төсвийн болон орон нутгийн өмчит 75 байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. 2022 оны 01 сарын 30-ны байдлаар шилэн дансны хуулийн хэрэгжилт 87.5 хувьтай байна.

### ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

#### Архивын тасаг:

Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд 2 хөмрөгийн 15 хадгаламжийн нэгжийн 389 заалт, 715 хүний нэр, 391 байгууллагын нэр, 1173 газар зүйн нэр, 586 хуудас баримтыг программд холбосон.

2022 оны 02 дугаар сард төрийн архиваас 9 иргэнд хуулбар, 3 иргэнд лавлагаа гаргаж үйлчилгээ үзүүлсэн.

#### Иргэний бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр гадаад паспорт захиалсан - 14
- Иргэний үнэмлэх шинээр олгосон - 7
- Төрснөө бүртгүүлсэн хүүхдийн тоо - 29
- Гэрлэлт бүртгүүлсэн тоо - 4

- Гэрлэлт цуцлуулснаа бүртгүүлсэн тоо - 2
- Овог, нэр өөрчлөлтийн бүртгэлийн тоо - 1
- Нас барсныг бүртгүүлсэн тоо - 7
- Өөр аймаг, хотоос шилжиж ирсэн нийт иргэн - 27
- Аймаг дотор шилжсэн иргэдийн тоо - 17

**Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:**

- Үл хөдлөх хөрөнгийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 5
- Газар өмчлөх эрхийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 20
- Гэрээний бүртгэл - 33
- Барьцааны гэрээний бүртгэл - 162
- Эд хөрөнгөд орсон өөрчлөлт, залруулга - 1

**Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр**

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэл - 3
- Хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт - 3

**Архивын чиглэлээр:**

- Төрийн байгууллагад гаргасан лавлагаа, хуулбар - 41
- Иргэнд гаргасан лавлагаа, хуулбар - 199

Нийт 575 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна.

**Цагдаагийн хэлтэс:** 2022 оны 02 дугаар сард иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 82 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаснаас гэмт хэргийн 20, зөрчлийн 62 гомдол мэдээлэл байна. Тайлангийн хугацаанд зөрчил гаргасан 45 иргэнийг эрх бүхий албан тушаалтнаас болон шүүхээс 14,205.0 мян.төгрөгийн торгууль ногдуулж, согтуугаар зөрчил гаргасан 54 хүнийг эрүүлжүүлж, 12 хүнийг шүүхээр баривчлуулан, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 29 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хассан.

Улсын хэмжээнд зохион байгуулагдсан “Сар шинэ-2022” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Цагдаагийн Хэлтсийн бие бүрэлдэхүүн өндөржүүлсэн бэлэн байдлын 1 дүгээр зэрэгт шилжин болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эргүүлийн үүрэг гүйцэтгэж, замын хөдөлгөөний аюулгүй байдлын журмын 20 зөрчил, гэр бүлийн хүчирхийллийн 1 зөрчлийг тус тус илрүүлэн шалгасан.

Тээврийн цагдаагийн албанаас явган зорчигчийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор зохион явуулж буй “Гэрлээр анхааруулъя” нөлөөллийн аяны хүрээнд Сүмбэр сумын Ерөнхий боловсролын 1, 2, 5 дугаар сургуулийн 6-8 дугаар ангийн 150 сурагч, Политехникийн коллежийн 40 оюутанд сургалт зохион байгуулсан.

**Шүүхийн шинжилгээний алба:** Хэргийн газрын үзлэгт 14 удаа оролцсоноос хүний амь нас хохирсон 4, зам тээврийн ослын 2, хулгайлах гэмт хэрэг 2, бусад хэргийн газрын үзлэгт 6 удаа, хэргийн газрын үзлэгийн болон эд мөрийн баримт, эрэн сурвалжлах, танин олуулах ажиллагаа, хэргийн газрын давтан үзлэг, нэгжлэг, цогцос задлан шинжлэх зэрэг ажиллагааны 413 кадр гэрэл зургийг боловсруулан холбогдох материалд хавсаргасан.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 425 дугаар нээлттэй хорих анги:** Тайлант хугацаанд 54 хүмүүжигчийг гэр бүлтэй нь цахимаар уулзуулсан. Хүмүүжигчдийг 13 төрлийн дугуйланд хамруулж байна.

Суллагдах дөхсөн 17 хүмүүжигчийг Нийгмийн халамжийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль зэрэг сэдвээр 9 удаагийн сургалтанд хамруулсан.

2022 оны 2 дугаар сард төлбөрийн 138 гүйцэтгэх баримт бичгийн 3665468,0 мян.төгрөг төвлөрүүлэхээс 10 гүйцэтгэх баримт бичгийн 185680,9 мян.төгрөг төвлөрүүлж, бодит биелэлт 13.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

**Мэргэжлийн хяналтын газар нь:** Иргэний хүсэлтийн дагуу шинээр үйл ажиллагаа эрхлэх хоол үйлдвэрлэлийн газарт зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, илэрсэн зөрчлийг үндэслэн 21 заалт бүхий хамтарсан зөвлөмж гаргаж хүргүүлэв.

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар Сүмбэр сумын 1-р багт үйл ажиллагаа явуулдаг Гаалийн хяналтын болон ачилт буулгалтын талбай бүхий 10 аж, ахуй нэгжийн 15 ажилтанд сургалт зохион байгуулсан.

Аж ахуй нэгж байгууллага, иргэний хүсэлтээр ирүүлсэн усны 4, хүнсний бүтээгдэхүүний 5, хоолны 11, нийт 20 сорьцод 97 үзүүлэлтээр хими, нян судлалын шинжилгээг гүйцэтгэсэн. Шинжилгээний дүнгээр усны 4 сорьц нь 5 үзүүлэлтээр стандартын шаардлага хангаагүй ба улсын байцаагчийн дүгнэлт гарган хүргүүлсэн.

**Онцгой байдлын газар нь:** Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд гамшиг ослын 4 удаагийн дуудлага бүртгэгдсэн байна.

Төлөвлөгөөт хяналт, шалгалтыг 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдрөөс 02 дугаар сарын 25-ны өдрүүдэд зохион байгуулав. Шалгалтаар давхардсан тоогоор 137 зөрчил илрүүлж, газар дээр 36 зөрчлийг арилгуулж, Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 20, дүгнэлт 1, мэдэгдэл 1, танилцуулга 1-ийг тус тус холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн.

Онцгой байдлын газрын даргын баталсан “Аюулгүй галлагаа” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Гамшиг, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтыг 3 удаа зохион байгуулж, Сүмбэр, Шивээговь, Баянтал сумын нийт 694 айл өрхийг хамруулан 412 зөрчил илрүүлж, газар дээр нь 40 зөрчлийг арилгуулж, 372 зөрчлийг арилгуулах талаар заавар зөвлөмж өгч, 1260 иргэнд галын аюулаас урьдчилан сэргийлэх, үнс нурам хадгалах сав, пийшин зуухны стандартын талаар тараах материал тарааж, болзошгүй гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт зохион байгуулан ажиллалаа.

Сүмбэр сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Шунхлай говь ХХК, Нарны цахилгаан станц, Магнай трейд ХХК ШТС-д Гал унтраах тархалтын сургууль, аймгийн 140 дүгээр салбарт Гал унтраах тактикийн сургуулийг зохион байгуулсан.

Галын аюулгүй байдлын тухай хууль, анхан шатны ойлголт сэдвээр танхимын сургалт хийж, гал унтраах дадлага, гал гарсан үед хамтран ажиллах сургууль, дадлага хийлээ.

Тус сургууль, дадлагад нийт 58 албан хаагч хамрагдсан байна.

Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөлтэй “Гамшгаас хамгаалах судалгаа шинжилгээний үндэсний төв”-өөс Сүмбэр сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Жаст-Ойл ХХК-ийн Шатахуун түгээх станцын гамшгийн эрсдэлийн үнэлгээний тайланг ирүүлсний дагуу анхан шатны хяналт шинжилгээ хийж, Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн эрсдэлийн удирдлагын газарт хүргүүлсэн.

### **ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

**Боловсролын чиглэлээр:** Боловсрол, шинжлэх ухааны яамнаас цахим платформ нэвтрүүлэх ажлыг орон нутагт хэрэгжүүлэх ажлын хүрээнд medle.mn цахим платформыг зайн сургалтанд нэвтрүүлэх, арга аргачлал, цаашид хэрэгжүүлэх ажлын саналыг хэлэлцэж, ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг цахим платформ дээр ажиллах, чадваржуулах сургалтыг онлайнаар зохион байгууллаа.

Бага боловсролын хүрээнд 2-5 дугаар ангийн Монгол хэл, Математик, Хүн байгалийн хичээлүүдээр аймгийн хэмжээнд оношлох үнэлгээний сэдэв боловсруулж, оношлох үнэлгээ зохион байгууллаа. Оношлох үнэлгээнд 56 бүлгийн 1600 сурагч хамрагдаж, үнэлгээний үр дүнд 2 дугаар улирлын сургалтын хөтөлбөрт тохируулга хийх талаар зөвлөмж өгч ажиллалаа.

Боловсролын чанарын шинэчлэл төслийн санхүүжилтээр “Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн 5 дугаар шатны төсөл”-ийн хүрээнд бага боловсролын “Цахим сан” төслийг хэрэгжүүлж байна.

“Муу найз” сэдэвт тамхи хорт зуршлын нөлөөний талаар “Өсвөрийн сэтгүүлч клуб”-тэй хамтран, дунд ангийн 168 сурагчид нөлөөллийн сургалтыг үе шаттай зохион байгуулж байна

**Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр:** “Хүүхдийн эрх, үүрэг оролцоо” хөтөлбөрийг 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрөөс Шивээговь сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуульд хэрэгжүүлэхээр эхлүүллээ. Хөтөлбөрийн хүрээнд багц сургалтуудыг 6-12 дугаар ангийн 300 сурагчдад зохион байгуулж, хувь хүний хөгжил, харилцаа хандлага, сэтгэл зүйн эерэг байдлыг хэрхэн бий болгох, амжилтын түлхүүр, асуудал бэрхшээл, түүнээс гарах арга зам сэдвийн хүрээнд мэдлэг, ойлголт өгч ажиллалаа.

**Соёл, урлагийн чиглэлээр:** Аймгийн Соёл урлагийн газар “Бүх нийтийн соёлын боловсрол” хөтөлбөрийн хүрээнд Сүмбэр, Баянтал, Шивээговь сумын 100 иргэнээс түүврийн судалгааг авч Соёлын яаманд хүргүүлсэн.

Боржигин чуулга нь иргэд олон түмэнд 34 үзвэр үйлчилгээг үзүүлж, нийт 12,682 хүнд соёл, урлагийн үйлчилгээг үзүүлсэн.

Нийтийн номын сан нь номын сангаар 12863 хүн үйлчлүүлснээс цахимаар 11273 иргэнд үйлчилсэн.

**Биеийн тамир, спортын чиглэлээр:** Дөрвөн жил тутамд зохион байгуулагддаг Монголын үндэсний спортын VII их наадамд мөсний шагай, мөсний сур харваа төрөлд 32 тамирчин оролцсон.

2022 оны 02 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн Засгийн газрын хэрэгжүүлэгч Агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооноос зохион байгуулж байгаа “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аяны хүрээнд өглөөний дасгалыг аймгийн спорт зааланд тогтмол зохион байгуулж байна.

Аймгийн усан бассейнаар 483 иргэд үйлчлүүлснээс 59 том хүн, 424 хүүхэд үйлчлүүлсэн.

### Эрүүл мэндийн чиглэлээр:

Үзүүлэлт	2021 оны 02 сар	2022 оны 02 сарын 20-ны байдлаар
Төрсөн эх	65	45
Гэрийн төрөлт	1	0
Амьд төрсөн хүүхэд	69	45
Амьгүй төрөлт	0	0
Нас баралт	14	11
Эмнэлгийн нас баралт	4	2
Хоног болоогүй нас баралт	3	1
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	0	2
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	0	0
Эмнэлгээс гарсан хүний тоо	530	757
Амбулаторийн үзлэг	15 465	12 354
Халдварт өвчин	3	1 877

**Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний чиглэлээр:** Орон нутгийн хэмжээнд сул, чөлөөтэй байгаа 14 ажил олгогчийн 46 ажлын байрны захиалгыг байгууллагын болон цахим мэдээллийн хэрэгслээр зарлаж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр арга хэмжээний талаарх ойлголт мэдээллийг өгч, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж, үйлчилгээ нь ЕНАЛАМЖ цахим системд нэвтэрсэнтэй холбоотойгоор иргэдэд дараах үйлчилгээг цахимаар үзүүлсэн. Үүнд:

- Халамжийн тэтгэвэр-250
- Нөхцөлт мөнгөн тэтгэмж-253
- Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж-55
- Жирэмсэн эхийн тэтгэмж-134
- Алдарт эхийн одонтой эхчүүдэд үзүүлэх мөнгөн тусламж-1375
- Цалинтай ээж-760
- Насны хишиг-711

Нийт 3538 иргэнд цахимаар төрийн үйлчилгээг хүргээд байна.

Тайлант сард хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд нийт 74 өрхийн 381 гишүүнд 4312,0 мянган төгрөгийг олгосон.

### ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Аймаг дундын Малах отрын бүс нутагт 2 аймаг 4 сумын 78 малчин өрхийн 40.1 мян.толгой мал буюу хонин толгойд шилжүүлснээр 56.7 толгой мал оторлож /Говьсүмбэр аймгийн 74 өрх, Дундговь аймгийн 4 өрх/ байна. Манай аймгаас Дорнод, Дорноговь, Хэнтий, Төв, Дундговь, Сүхбаатар аймагт нийт 22 өрхийн 17.3 мян.тол мал отроор өвөлжиж, хаваржиж байна.

Малах отрын бүсээс гадна Баянтал, Сүмбэр сумын нутагт Дундговь, Төв аймгийн сумдаас 22 өрхийн 23,7 мян.тол мал зөвшөөрөлгүй отроор өвөлжиж, хаваржиж байна. Зөвшөөрөлгүй байгаа отрын малын шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, журам зөрчсөн малчдад хуулийн хариуцлага тооцох, гарсан зөрчлийг арилгуулахаар аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу ажлын хэсэг явж ажилласан.

Японы Жайка төслийн хүрээнд 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдөр “Гарааны бизнесийг хөгжүүлэх, инновац шингэсэн техник нэвтрүүлэх, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдээр дамжуулан орон нутгийн онцлогийг тусгасан бүтээгдэхүүн үйлдвэрлэх” сэдэвт сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулав. Тус сургалтад орон нутгийн 12 аж ахуйн нэгж хамрагдсан.

“Татварын шинэчлэлийн талаарх мэдээлэл, татвар төлөгчийн бүртгэл хөтлөх, тайлагнах, татвар төлөхтэй холбоотой зардлыг бууруулах татварын үйлчилгээг цахим, ил тод, энгийн болгох” талаарх сургалтыг зохион байгуулж, сургалтад орон нутгийн бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч, хоршооны удирдлага, менежер, нягтлан бодогчдын төлөөлөл 21 иргэн хамрагдсан.

Аймгийн дүнгээр мах 134 тн буюу 80, гурил 82.2 тн буюу 59, сүү 3 тн буюу 1, төрөл бүрийн будаа 15 тн буюу 22, төмс 8.9 тн буюу 5, хүнсний ногоо 7.7 тн буюу 2, элсэн чихэр 5.6 тн буюу 12, давс 4 тн буюу 14, савласан ус 237 тн буюу 1, өндөг 0.6 тн буюу 2, ургамлын тос 3 тн буюу 10 хоногийн нөөцтэй байна.

### **Аймгийн төвийн захууд, томоохон худалдааны төвүүдийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийг өнгөрсөн сарын үнэтэй харьцуулан гаргасан 2022 оны 02 дугаар сарын үнийн мэдээ**

Зах зээлд худалдаалагдаж буй зарим хүнсний бараа бүтээгдэхүүний үнэ өнгөрсөн сараас 50-500 төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Тухайлбал: үхрийн мах /цул/ 500 төгрөгөөр буюу 3.6%, хонины ястай мах 250 төгрөгөөр буюу 2.8%, лууван 50 төгрөгөөр буюу 2%, төмс 150 төгрөгөөр буюу 8.9%, цагаан будаа 200 төгрөгөөр буюу 5%, Сүү /задгай/ 300 төгрөгөөр буюу 7.7%, Алтан тариа /1-р гурил/ 150 төгрөгөөр буюу 9% тус тус өссөн үзүүлэлттэй байна. Бусад бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байна.

Үнийн мэдээг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулан үзэхэд малын мах төрөл тус бүрээр 500-1000 төгрөгөөр буюу 5.8-8.7%, Төмс, хүнсний ногоо 100-500 төгрөгөөр буюу 10-50%, Сүү 150 төгрөгөөр буюу 4.7%, Гурил 50-100 төгрөгөөр буюу 2.7-4.1% тус тус өссөн байна. Импортын барааны үнэ тухайлбал, элсэн чихэр 3.3%, цагаан будаа 12.5%, ургамлын тос 12.8% өссөн дүнтэй байна.

№	Бараа бүтээгдэхүүн	Дээд үнэ төг	Доод үнэ төг	Өссөн буурсан /1-р сараас /	
1	Үхрийн мах	Ястай	13000	11500	+500
		Цул	14000	13000	-
2	Хонины мах	Ястай	9000	8500	+250
		Цул	12000	11000	-
3	Адууны мах	Ястай	8500	8000	-
		Цул	10000	9000	-
4	Ямааны мах	Ястай	7500	6500	-
		Цул	8500	8000	-
5	Лууван	монгол	2500	2000	+50
		хятад			
6	төмс	монгол	1680	1000	+150
		хятад			
7	Байцаа	монгол	2000	1800	-
		хятад			-
8	чинжүү	монгол	13000	11000	-
		хятад	13000	1100	
9		монгол	2000	1800	

	Манжин	хятад			-
10	Сонгино бөөрөнхий	Монгол	4000	1800	-
		Хятад	3800-	1500	-
11	Помидор	монгол	13000	8000	-
12	Өргөст хэмх	монгол	15000	12000	-
13	Элсэн чихэр		3000	2300	-
14	Будаа	Цагаан задгай кг	4000	2400	+200
		Шар слава кг	3800	3000	-
		Гурвалжин будаа кг	3800	2200	-
15	Сүү	Задгай	3900	3200	+300
		Сүү ХХК 0,5л			
		Сүү ХХК 1л	3200	2900	-
16	Тараг	Задгай	2200	2000	-
		Сүү ХХК 1л цөцгийтэй тараг	4800	3800	-
17	Талх	Чойр талх	4500	1150	-
18	Өндөг	Монгол	550	440	-
19	Алтан тарианы гурил	Задгай дээд	1800	1480	+150
		Задгай 1-р зэрэг	1650	1280	+100
		Задгай 2-р зэрэг	1000	950	-
		Савласан д/дээд /	2400	2300	-
		Савласан дээд	2200	2100	-
		Савласан 1-р зэрэг	1400	1300	-
		Савласан 2-р зэрэг	1500	1450	-
20	Ургамлын тос	Олейна	8800	7500	-
		Алтан	6500	4500	-

### **ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

**Байгаль орчны чиглэлээр:** Сүмбэр сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт ачилт буулгалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудын удирдлагуудтай аймгийн Засаг даргын орлогч, холбогдох мэргэжлийн байгууллагын удирдлагууд уулзалт хийж, орон нутгаас хийж хэрэгжүүлж буй ажил, бодлого шийдвэрийн талаар мэдээлэл танилцуулсан.

Уулзалтаар ачилт буулгалтын үеэр үүсэж буй тоос тоосонцор нь хүн амын эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах эрх зөрчигдөж байгаа нөхцөл байдал үүсч байгаа тул орон нутгийн зүгээс авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар танилцуулж, цаашид тоосжилтыг бууруулах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгүүлэхээр хугацаатай үүрэг, чиглэл өгч ажиллалаа. Үүнд:

- Ачилт буулгалтын талбай бүр нурмаг ачааг тоосжилтоос хамгаалах зориулалтын хашааг барьж байгуулах
- Ачилт буулгалтын доторх талбайг хатуу хучилттай болгох
- Хяналтын постоос ачилт буулгалтын талбай хүртэл замыг хайрган хучилттай болгох
- Орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах
- “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хуваарилагдсан талбайд мод бут тарьж, ургуулах
- Хуримтлагдсан хог хаягдал болон ачилт буулгалтын талбайн ойр орчмын ахуйн хог хаягдлыг тогтмол цэвэрлэж хэвших

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод үржүүлгийн газрыг өргөжүүлэх зорилгоор 4 га талбайд ашиглах зөөврийн бороожуулагч усалгааны систем худалдан авахаар Мөнх ногоон тал ХХК-тай гэрээ хийсэн.

Тайлант сард азотын давхар исэл (NO<sub>2</sub>) болон хүхэрлэг хийн давхар ислийг (SO<sub>2</sub>) хоногт 3 удаагийн давтамжтайгаар сорьцыг 30 удаа, мөн шинжилгээг 10 удаагийн дээжинд

хийж, дундаж азотын давхар исэл (NO<sub>2</sub>) 0.012 мкг/м<sup>3</sup>, сарын хүлцэх агууламж хэмжээ 0.200 мкг/м<sup>3</sup>, хүхэрлэг хийн давхар исэл (SO<sub>2</sub>) 0.025 мкг/м<sup>3</sup> байгаа нь хүлцэх агууламжаас хэтрээгүй байна.

Агаар бохирдуулагч эх үүсвэр 2022 онд 3-15 кВт-ын зуухтай 1-р багийн 164 айл өрх, 2-р багийн 644 айл өрх, 3-р багийн 225 айл өрх, Шивээговь сумын 209 айл өрх, Баянтал сумын 78 айл өрх, 15-100 кВт-ын 9 аж ахуй, 100-4200 кВт 6 ОНӨААТҮГазар тооллогыг хийж орчны бохирдлын мэдээллийн сан дээр шивэлт хийж байна. Сүмбэр сумын айл өрхийн тооллого 98 хувьтай явагдаж байна.

**Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар:** Газрын төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан Сүмбэр, Баянтал, Шивээговь сумдад хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт 74 иргэн оролцсоноос 63 иргэн одоо байгаа үнэлгээг хэвээр байлгах саналыг гаргасан байна.

Газрын төлбөрийг 1502 нэгж талбарт 304,5 сая төгрөгийн ногдуулалтыг хийн татварын хэлтэст илгээн ажилласан.

Аймгийн Төвийн гэрэлтүүлгийн ажил 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдөр Улсын комисс ажиллаж холбогдох үүрэг даалгавар өгч, байнгын ашиглалтанд хүлээн авахаар шийдвэрлэсэн.

**Худалдан авах ажиллагааны талаар:** Төсвийн ерөнхийлөн захирагч 2022 онд нийт 3 858,937.9 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 28 бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөснөөс 15 тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж, худалдан авах ажиллагааны явц 53.5 хувьтай байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 13 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 5 ажил, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийт 12 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 5 ажлын тендер шалгаруулалтыг тус тус зарлаад байна. Зарлагдсан тендерийн урилгуудыг “Монголын үнэн” сонин, [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn), [govisumber.gov.mn](http://govisumber.gov.mn) сайтуудад тухай бүр нийтэлж, тендер шалгаруулалтыг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулж тендер шалгаруулалтын үр дүнг тухай бүрт цахим системд оруулан ажиллаж байна.

Орон нутгийн харилцааны асуудлаар мэргэжил арга зүйн зөвлөгөөг тухай бүр өгч, хуулийн этгээдүүдийн 2021 оны “Өмч эзэмшүүлэх гэрээ”-г байгуулан, 2021 оны жилийн эцсээрх аймгийн өмчийн мэдээ тайланг нэгтгэн, байгууллагуудын 2021 оны хөрөнгийн хөдөлгөөнд хяналт тавьж, жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулж дууссан байна. Нийт 4 байгууллагад зөвлөмж хүргүүлж балансад нь залруулга хийлгэсэн болно.

2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар түрээсийн орлого 3.0 сая төгрөг төвлөрсөн байгаа ба нийт төвлөрөх орлогын 50 хувийн гүйцэтгэлийг хангаад байна.

## **ДОЛОО. СУМ ОРОН НУТГИЙН ТАЛААР**

**Баянтал сум:** Сар шинийн баярын өдрийг тохиолдуулан сумын нийт албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэд нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж, нийт 20 тн гаруй хог хаягдлыг цэвэрлэж нэгдсэн хогийн цэгт хаясан.

“Нэг өрх- Нэг ажлын байр” хөтөлбөр арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг сумын Засаг даргын захирамжаар байгуулж, тус хөтөлбөрт хамрагдах 28 өрхийг сонгосон.

**Шивээговь сум:** Аймгийн онцгой комиссын газраас зарласан Аюулгүй галлагаа аянд нэгдэж Ердийн галлагаатай 131 өрхөд галын аюулгүй байдлын үзлэг хийж заавар зөвлөмж өгсөн. Сумын төвийн нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж 17 байгууллага, аж ахуй нэгжийн 117 ажилтан, албан хаагч оролцлоо.

**Сүмбэр сум:** Сар шинийн баяр, амралтын өдрүүдэд иргэд, аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд халдвар хамгааллын дэглэм сахиулах ажлын хүрээнд сумын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйч, багийн Засаг дарга нар хамтран худалдаа үйлчилгээний 21 газар, ил задгай худалдаа хийж байсан 2 иргэнд хүнсний аюулгүй байдлыг хангаж ажиллах, гарал үүсэл нь тодорхой бус, хаяг шошгогүй бүтээгдэхүүн худалдан борлуулахгүй байх талаар заавар зөвлөмж өгч, хяналт тавьж ажилласан.

Төрийн үйлчилгээний E-Mongolia системээр 131 иргэнд үйлчилгээ үзүүлсэн.

2021 онд зохион байгуулсан “Архидалтгүй Сүмбэр 1, 2” арга хэмжээнд хамрагдсан 31 иргэнтэй уулзалт хийсэн бөгөөд эмчилгээний үр дүн 90,3 хувьтай байна.

Японы хүүхдийг ивээх сангаас хэрэгжүүлж буй “Өсвөр залуу үеийнхэнд интерпренершипийн боловсрол олгох хөтөлбөр”-ийн Сүмбэр суман дахь зөвлөл хуралдаж 2022 онд хийх ажлын төлөвлөгөө боловсруулсан.

2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 2 зээлдэгч зээлээ бүрэн төлж барагдуулан 14 зээлдэгч зээлийн эргэн төлөлт хийж, 45,1 сая төгрөгийн эргэн төлөлт төвлөрсөн байна. Төлөвлөгөөний дагуу 34,0 сая төгрөг төвлөрүүлэхээс 45,1 сая төгрөг төвлөрүүлсэн. Одоогоор сум хөгжүүлэх сангийн дансанд нийт 407,8 сая төгрөг төвлөрөөд байна.

Иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх үүднээс 70543232 дугаарт Callpro үйлчилгээг нэвтрүүлж Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Газрын алба, Улсын бүртгэл, Хот тохижилт, Сүмбэр сум гэх байгууллагын иргэний бүртгэл, нийгмийн халамж, ажил зуучлал, хөдөлмөр эрхлэлт, газар, хог ачилт тээвэрлэлттэй холбоотой мэдээлэл авах мөн өргөдөл, гомдлыг операторын дуудлага хүлээн авах боломжтой болсон.

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**